



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/159

Мандалговь

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгж Түүний Удирдлагын Тухай Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйл, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 Засгийн газрын 2008 оны 305 дугаар тогтоол, Улсын байцаагчийн 2017 оны 13-02-315/17 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тус сумын “Үйзэн” багийн нутаг “Баруун элгэн”-д нутаглаж байгаа Өлзийт сумын 2-р багийн О.Энхбатын хонь, ямаанд малын гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэг илэрсэн нь тогтоогдсон тул 2017 оны 08 сарын 10-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, эрүүл бүсээс мал, мах, сүү сүүн бүтээгдэхүүнийг ариун цэврийн гэрчилгээтэй худалдаалахыг зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж тухай бүр мэдээллээр хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ч.Ганбаатар/, ЗДТГазрын дарга /Б.Оюунчимэг/, Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга /Р.Булгантамир/, багийн Засаг дарга /Т.Батжаргал/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

